



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Санхүүгийн аудитын тайлан

Дүгнэлт: Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг үр дүнтэй зарцуулсан байна.

2021 оны 07 дугаар сар

Аудитын сэдэв: “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Дорнод аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын төлөвлөлт, зарцуулалт”-д хийсэн аудитын тайлан

2021 он



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
Ерөнхий мэдээлэл.....	5

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРАМ, АРГАЧЛАЛЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ ХУВААРИЛСАН БАЙНА.

1.1. Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.....	5
---	---

1.2. Сонгуулийн хороодод төсвийг аргачлал, зөвлөмжийн дагуу тооцон хуваарилсан байна.....	7
---	---

БҮЛЭГ 2. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА..

2.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн зардалд улсын төсвөөс хуваарилсан 511,691.4 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, зарцуулсан байна.....	8
--	---

2.2. Аймаг, сумдын Сонгуулийн хороо төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.....	9
---	---

ДҮГНЭЛТ:	11
ЗӨВЛӨМЖ:	11
ТУШААЛ:	12



Товчилсон үгийн тайлбар

СА	Санхүүгийн аудит
ШТА	Шууд тайлагнах аудит
ДОА	Дорнод аймаг
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
МУЕ	Монгол Улсын Ерөнхийлөгч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОБГ	Онцгой байдлын газар
УБЕГ	Улсын бүртгэлийг ерөнхий газар
МТБ	Мэдээлэл технологийн баг



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8¹, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Дорнод аймгийн сонгуулийн хорооны зардлын төлөвлөлт, зарцуулалт”-д Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3²-т заасныг баримтлан санхүүгийн аудит хийлээ.

Аудитын зорилт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Дорнод аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын төлөвлөлт, зарцуулалтад дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аймгийн Сонгуулийн хороо холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- МУЕ-ийн 2021 оны сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам зориулалтын дагуу хуваарилсан эсэх.
- МУЕ-ийн 2021 оны сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан СЕХ-ноос Дорнод аймгийн Сонгуулийн хороонд хуваарилан зарцуулсан төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, аймгийн болон 14 сумдын Сонгуулийн хороо, Онцгой байдлын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газрын санхүүгийн баримт, материалыг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-1, 6817-5, 6817-7, МУЕА-ын 2020 оны “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг баримтлан шалгадагч болон хамрагдагч байгууллагын сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалыг шалгах, асуулга лавлагаа, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, харьцуулах, нэгтгэх зэрэг аудитын горимыг ашиглав.

¹ Хуулийн 9.8-д Энэ хуулийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын дээд байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу хяналт тавьж, аудит хийж, дүгнэлт гаргана.

² Хуулийн 6.3. Төрийн аудитын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.3.1. шалгадагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дэлгэрмаа, гэрээт аудитор З.Шинэхүү, Б.Оюунхэрлэн, Ч.Удвалноров нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ. Аудитын талбарын ажлыг 2021 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс эхлүүлж, тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Аймгийн Сонгуулийн хорооны даргад 2021 оны 07 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Улсын Их Хурлаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр шинэчлэн баталж, 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс даган мөрдөж эхэлсэн байна.

Дорнод аймгийн Сонгуулийн хороонд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх 511,691.4 мянган төгрөгийн зардлыг СЕХ-ны Ажлын албаны 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 3/124 тоот албан бичгийн 2 дугаар хавсралтаар баталсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит 2021 оны сонгуулиар Дорнод аймагт аймгийн Сонгуулийн хороо, 14 сумын Сонгуулийн хороо, 72 хэсгийн хороонд төрийн жинхэнэ болон үйлчилгээний нийт 661 албан хаагчид томилогдон ажилласан байна. Үүнээс аймгийн Сонгуулийн хороонд 9, салбар хороонд 98, хэсгийн хороонд 554 албан хаагч ажилласан байна. Засгийн газрын 2021 оны 152-р тогтоолоор батлагдсан “Түр журам”-ыг үндэслэн коронавирус цар тахлаас урьдчилан сэргийлэх ариутгал, халдваргүйжүүлэлтийг хариуцах ажлын хүрээнд Мэргэжлийн хяналтын газар болон Эрүүл мэндийн байгууллагаас 36 төрийн албан хаагч ажилласан байна.

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРАМ, АРГАЧЛАЛЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ ХУВААРИЛСАН БАЙНА.

1.1 Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих” журмын 2.1-т “Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчдын тоо, сум дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна” гэж заасны дагуу Дорнод аймагт Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагааны зардлын санхүүжилтэд 511,691.4 мянган төгрөгийн төсвийг баталж хуваарилсан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны санхүүжилтийг Төрийн сан дахь 100070022001 тоот дансаар дамжуулан гүйцэтгэсэн бөгөөд 3 удаагийн санхүүжилтээр нийт 511,691.4 мянган төгрөгийг авсан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны ажлын албанаас 2021 оны 3/71, 3/103, 3/124 тоот албан бичгээр салбар, хэсгийн хорооны тоо, ажиллагсдын тоо, газар нутгийн байршил, сонгогчдын тоо зэргийг харгалзан санхүүжилтийг хуваарилах аргачлал, зөвлөмжийг ирүүлсэн байна.

Олгосон төсвийг зардлын нэр төрлөөр харуулав. Хүснэгт №1

№	Зардлын нэр	Төсөв /мян.төг/	Хувь
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	250.0	0.05
2	МТБ-ийн гишүүн, даамлын сургалтын зардал	9,180.0	1.79
3	Сонгуулийн байгууллагын ажилтан, сургалтын зардал	3,834.0	0.75
4	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны бичиг хэргийн зардал	11,880.0	2.32
5	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны шуудан холбооны зардал	13,900.0	2.72
6	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны унааны зардал	42,650.0	8.34
7	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	23,040.0	4.50
8	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	18,674.0	3.65
9	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	2,000.0	0.39
10	Мэдээ дамжуулах унааны зардал	2,255.0	0.44
11	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	3,240.0	0.63
12	Сурталчилгааны зардал	5,000.0	0.98
13	Томилолтын зардал	6,378.4	1.25
14	Болзошгүй зардал	10,000.0	1.95
15	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	315,550.0	61.67
16	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	43,860.0	8.57
	Нийт дүн	511,691.4	100.0

Эх сурвалж: /Дорнод аймгийн сонгуулийн хорооны тайлан/

Дээрх хүснэгтээс харахад нийт зардлын 70.3 хувийг аймаг, сумдын сонгуулийн болон хэсгийн хороодод ажилласан албан хаагч, МТБ-ийн гишүүн, санал авах байрны даамлын урамшуулал, хоолны зардалд, 29.7 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулахаар баталсан байна.

Сонгууль зохион байгуулахтай холбоотой Дорнод аймагт Сонгуулийн Ерөнхий хорооны санхүүжилтээс гадна Засгийн газрын нөөц сангаас Онцгой байдлын газарт 36,735.5 мянган төгрөгийн амны хаалт, хамгаалах хэрэгсэл, Цагдаагийн газарт 14,275.0 мянган төгрөгийн, Улсын бүртгэлийн хэлтэст 67,944.4 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус нэмэлтээр ирүүлсэн байна.

Нийт ирсэн санхүүжилт болон материалын дүн хүснэгтээр харуулав. Хүснэгт №2

№	Нэмэлт санхүүжилт болон материал ирүүлсэн байгууллагын нэр	Нэмэлт санхүүжилт болон материалын зардлын дүн /мян.төг/
1	Сонгуулийн Ерөнхий хороо	511,691.4
2	Онцгой байдлын Ерөнхий газар	36,735.5
3	Цагдаагийн Ерөнхий газар	14,275.0
4	Улсын бүртгэлийн Ерөнхий газар	67,944.4
	Нийт дүн	630,646.3

Онцгой байдлын ерөнхий газраас ковид-19 цар тахлын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд сонгогчид болон сонгуулийн байранд ажиллах албан хаагчдад шаардлагатай амны хаалт, хамгаалах хэрэгсэл болон ариутгал,



халдваргүйжүүлэлтийн бодис болох 5 нэр төрлийн нийт 36,735.5 мянган төгрөгийн материалыг, Цагдаагийн ерөнхий газраас сонгуулийн хамгаалалтад ажиллаж байгаа албан хаагчдын хоол, шуудан холбоо, шатахууны зардалд нийт 14,275.0 мянган төгрөгийн санхүүжилтийг, Улсын бүртгэлийн ерөнхий газраас сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал, сургалт, сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх, хүргэх зардал, техникийн хэвийн үйл ажиллагааг хангахад нийт 67,944.4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг олгосон байна.

1.2 Сонгуулийн хороодод төсвийг аргачлал, зөвлөмжийн дагуу тооцон хуваарилсан байна.

Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороодод хуваарилсан төсвийг хянаж үзэхэд Сонгуулийн Ерөнхий хорооны ажлын албаны 2021 оны 3/71, 3/103, 3/124 тоот албан бичгээр ирүүлсэн салбар, хэсгийн хорооны тоо, ажиллагсдын тоо, газар нутгийн байршил, сонгогчдын тоо зэргийг харгалзан санхүүжилтийг хуваарилах аргачлал, зөвлөмжийн дагуу хуваарилсан байна.

Тухайлбал:

- Бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг аймаг, сум, хэсгийн сонгуулийн хороодод тогтмол мөнгөн дүнгээр,
- Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх, сурталчилгааны зардлыг аймгийн Сонгуулийн хороонд тогтмол мөнгөн дүнгээр,
- Урамшуулал, хоолны зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны даргын “Урамшуулал, хоолны хэмжээ тогтоох тухай” 2021 оны А/34 дүгээр захирамжийн дагуу,
- Унааны зардлыг газар нутгийн байршил, хэсгийн хороо, ажиллагсдын тоог харгалзан тус тус хуваарилсан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нийт батлагдсан 511.7 сая төгрөгийн зардлын 409.6 сая төгрөгийг 14 сумын сонгуулийн хороодод, 102.1 сая төгрөгийг аймгийн Сонгуулийн хороонд зарцуулахаар тус тус хуваарилсан байна.

Сумдын сонгуулийн хороодод хуваарилсан зардлын төсвийн нийт дүнд эзлэх хувийг сумдын хэсгийн хороодын зардлын эзлэх хувьтай харьцуулахад 0.1-0.9 нэгж хувиар хэлбэлзэлтэй байгаагаас харахад зардлын төсвийг хэсгийн хорооны тоотой уялдуулан хуваарилсан байна.



Сумдын сонгуулийн хороодод олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулав. Хүснэгт № 3

№	Сонгуулийн хороодын нэрс	Хэсгийн хорооны тоо	Зардлын төсөв /сая төгрөг/	Хэсгийн хорооны эзлэх хувь	Зардлын эзлэх хувь	Зөрүү
1	Баяндун сумын Сонгуулийн хороо	4	22.4	5.6	5.5	0.1
2	Баянтүмэн сумын Сонгуулийн хороо	4	22.0	5.6	5.4	0.2
3	Баян-Уул сумын Сонгуулийн хороо	6	33.2	8.3	8.1	0.2
4	Булган сумын Сонгуулийн хороо	4	22.1	5.6	5.4	0.2
5	Гурванзагал сумын Сонгуулийн хороо	3	18.4	4.2	4.5	0.3
6	Дашбалбар сумын Сонгуулийн хороо	5	27.0	6.9	6.6	0.3
7	Матад сумын Сонгуулийн хороо	5	29.0	6.9	7.1	0.2
8	Сэргэлэн сумын Сонгуулийн хороо	3	17.9	4.2	4.4	0.2
9	Халхгол сумын Сонгуулийн хороо	4	23.6	5.6	5.8	0.2
10	Хөлөнбуйр сумын Сонгуулийн хороо	3	18.0	4.2	4.4	0.2
11	Хэрлэн сумын Сонгуулийн хороо	18	100.1	25.0	24.4	0.6
12	Цагаан-Овоо сумын Сонгуулийн хороо	6	31.4	8.3	7.7	0.6
13	Чойбалсан сумын Сонгуулийн хороо	4	23.3	5.6	5.7	0.1
14	Чулуунхороот сумын Сонгуулийн хороо	3	21.2	4.2	5.1	0.9
	Нийт дүн	72	409.6	100.0	100.0	

Эх сурвалж: /Дорнод аймгийн сонгуулийн хорооны тайлан/

БҮЛЭГ 2. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

2.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн зардалд улсын төсвөөс хуваарилсан 511,691.4 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, зарцуулсан байна.

Сонгуулийн хороодын зардлын зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлийн мэдээ, дансны хуулга, анхан шатны баримтуудтай тулган шалгахад баталсан төсвийг ангилал хооронд гүйлгэн зарцуулсан зөрчил илрээгүй.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан ч Сангийн Сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй Аймгийн Сонгуулийн хороо, Хэрлэн, Хөлөнбуйр зэрэг сумдын сонгуулийн хороод и-баримт цахим системд бүртгүүлээгүй нийт 13,369.2 мянган төгрөгийн



зарлагын 5 гүйлгээ хийснийг аудитын явцад илрүүлж Татварын нэгдсэн системд нөхөж бүртгүүлээ.

2.2. Аймаг, сумдын Сонгуулийн хороо төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

Аймгийн Сонгуулийн хороо төсвийн гүйцэтгэлийн мэдээг сумдын сонгуулийн хороодоос авч хянан нэгтгэж үнэн зөв тайлагнасан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны сонгуулийн нэгдсэн зардлын задаргааг хүснэгтээр харуулав.
Хүснэгт №4

д/д	Зардлын нэр төрөл	Төсөв /мян.төг/		
		Батлагдсан 2021 он	Зарцуулсан 2021 он	Зөрүү
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	250.0	250.0	0.0
2	МТБ-ийн гишүүн, даамлын сургалтын зардал	9,180.0	9,180.0	0.0
3	Сонгуулийн байгууллагын ажилтан, сургалтын зардал	3,834.0	3,834.0	0.0
4	Бичиг хэргийн зардал	11,880.0	11,880.0	0.0
5	Шуудан холбооны зардал	13,900.0	13,900.0	0.0
6	Унааны зардал	42,650.0	42,650.0	0.0
7	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	23,040.0	23,040.0	0.0
8	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	18,674.0	18,674.0	0.0
9	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	2,000.0	2,000.0	0.0
10	Мэдээ дамжуулах унааны зардал	2,255.0	2,255.0	0.0
11	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	3,240.0	3,240.0	0.0
12	Сурталчилгааны зардал	5,000.0	5,000.0	0.0
13	Томилолтын зардал	6,378.4	6,378.4	0.0
14	Болзошгүй зардал	10,000.0	10,000.0	0.0
15	Хэсгийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	315,550.0	315,550.0	0.0
16	Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	43,860.0	43,860.0	0.0
ДҮН		511,691.4	511,691.4	0.0

Эх сурвалж: /Дорнод аймгийн Сонгуулийн хорооны тайлан/

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/112 тоот тушаалаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгууль зохион байгуулахад коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд сонгогчид болон сонгуулийн байранд ажиллах албан хаагчдад шаардлагатай 5 нэр төрлийн 36,737.5 мянган төгрөгийн амны хаалт, хамгаалах хэрэгслийг улсын нөөцөөс хуваарилж хүргүүлсэн байна. Эдгээр амны хаалт, хамгаалах хэрэгслийг аймгийн Сонгуулийн хороо, Онцгой байдлын газар болон 14 сумын сонгуулийн хороодод хуваарилж, сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулаагүй үлдсэн 210.0 мянган төгрөгийн 700ш нэг удаагийн амны хаалтыг улсын нөөцөд буцаан төвлөрүүлсэн байна.

Амны хаалт хамгаалах хэрэгслийн хуваарилалтын задаргаа. Хүснэгт №5

д/д	Сонгуулийн хороодын нэр	Материалын нэр /тоогоор/				
		Нэг удаагийн амны хаалт	Нэг удаагийн бээлий	Нүүрний хаалт	Гар ариутгагч	Хамгаалах хувцас
1	Улсын нөөцөөс хуваарилсан	62377	4384	216	1204	288
2	Баяндун сумын Сонгуулийн хороо	2250	210	8	60	8
3	Баянтүмэн сумын Сонгуулийн хороо	2150	210	8	60	8
4	Баян-Уул сумын Сонгуулийн хороо	3370	318	12	90	16
5	Булган сумын Сонгуулийн хороо	1650	210	8	60	8
6	Гурванзагал сумын Сонгуулийн хороо	1180	168	6	45	6
7	Дашбалбар сумын Сонгуулийн хороо	2420	252	10	75	14
8	Матад сумын Сонгуулийн хороо	2440	264	10	75	10
9	Халхгол сумын Сонгуулийн хороо	2650	210	8	60	8
10	Хөлөнбуйр сумын Сонгуулийн хороо	1480	168	6	45	6
11	Сэргэлэн сумын Сонгуулийн хороо	1480	168	6	45	6
12	Цагаан-Овоо сумын Сонгуулийн хороо	2790	294	12	90	16
13	Чойбалсан сумын Сонгуулийн хороо	2270	222	8	60	8
14	Чулуунхороот сумын Сонгуулийн хороо	1540	204	6	45	8
15	Хэрлэн сумын Сонгуулийн хороо	30390	972	90	27	108
16	Онцгой байдлын газар	557	42			
17	Аймгийн Сонгуулийн хороо	3060	472	18	124	60
НИЙТ ДҮН		61677	4384	216	1204	288
ҮЛДЭГДЭЛ /буцаан төвлөрүүлсэн/		700	0	0	0	0

Эх сурвалж: /Бүсийн төв Онцгой байдлын газрын тайлан/

Аймаг, сумдын Сонгуулийн хороод нь дээрх нэр төрлийн материалыг давхардуулж худалдан авалт хийгээгүй байна.

Цагдаагийн ерөнхий газраас Дорнод аймаг дахь Цагдаагийн газарт Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбоотой хэв журмын хамгаалалтын зардалд /үүрэг гүйцэтгэх албан хаагчдын хоолны зардалд 10,215.0 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 3060.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 1,000.0 мянган төгрөг/ нийт 14275.0 мянган төгрөг хуваарилсныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

УБЕГ-ын даргын “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлах тухай” 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/176 тоот тушаалаар Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэст нийт 67,947.0 мянган төгрөг хуваарилсныг дараах зардлуудад зарцуулсан байна. Үүнд:

- Мөнгөн урамшууллын зардалд 46,224.2 мянган төгрөг
- Бичиг хэргийн зардалд 3,425.7 мянган төгрөг
- Шатахууны зардалд 3,414.0 мянган төгрөг
- Томилолтын зардалд 10,254.3 мянган төгрөг
- Тээврийн зардалд 3,200.0 мянган төгрөг



- Сургалтын зардалд 1,231.2 мянган төгрөг
- Шуурхай багийн зардалд 195.0 мянган төгрөгийг буюу нийт 67,944.4 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 2.6 мянган төгрөг байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.
2. Сонгуулийн хороодод төсвийг аргачлал, зөвлөмжийн дагуу тооцон хуваарилсан байна.
3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
4. Аймаг, сумын Сонгуулийн хороо төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.
5. Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.
6. Аймгийн Сонгуулийн хороо хөрөнгийн зарцуулалтад журмын дагуу хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн цаашид дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Сонгуулийн хорооны дарга П.Бат-Өлзийд зөвлөж байна.

1. Сангийн Сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 14

Чойбалсан хот

Г

Тайлан баталгаажуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Дорнод аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын төлөвлөлт, зарцуулалт"-т хийсэн санхүүгийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг аймгийн Сонгуулийн хорооны дарга П.Бат-Өлзийд хүргүүлсүгэй.

3. Санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010001